



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН
ДААТГАЛЫН ТӨСӨЛ



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН 2006 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

УЛААНБААТАР ХОТ
2006 он



МИД-ын 2006 оны борлуулалтын улиралд хийн гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан МИД-ын “Хөгжлийн зээлийн гэрээ”, “Төсөл хэрэгжүүлэх заавар”, ажлын төлөвлөгөөний дагуу МИД-ын 2006 оны борлуулалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:


Огноо	Үйл ажиллагаа
2005 оны 9-р сар	<ul style="list-style-type: none">Дотоодын даатгалын компаниудад МИД-ын талаар сургалт зохион байгуулж, төслийн үйл ажиллагаа, төсөлд оролцох шаардлагыг танилцуулсан.МИД төслийн хэрэгжилтийн явцад зөвлөх үйлчилгээ үзүүлэгч олон улсын зөвлөхтэй гэрээ байгуулсан.
11-12-р сар	<ul style="list-style-type: none">МИД-ын 2006 оны борлуулалтын улиралд оролцох даатгалын компаниудыг сонгон шалгаруулав.МИД-ын борлуулалтыг үр дүнтэй зохион байгуулах болон тэмээн сүргийг МИД-д хамруулах талаар санал боловсруулсан.
1-р сар	<ul style="list-style-type: none">МИД-ын зарчим, үйл ажиллагааны талаарх даатгалын компанийн сургагч багш, сумдын ажилтнууд, даатгалын төлөөлөгчид, орон нутгийн удирдлагуудад зориулсан гарын авлагыг боловсруулсан.Даатгалын компанийн сургагч багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан.
2-р сар	<ul style="list-style-type: none">Оролцогч даатгалын компаниудтай МИД-ын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан.ҮДБ-ний стандарт гэрээг боловсруулсан.ГХБ-нд хамруулах журмыг баталсан.МИД-ын 2006 оны борлуулалтын улиралд ашиглагдах даатгалын баталгааны маягт, гэрчилгээ, дардасын загварыг боловсруулан хэвлэсэн.Даатгалын төлөөлөгчдийн бүртгэн эрх олгох сургалтын агуулга, шалгалтын материалыг боловсруулав.МИД-ын санхүүгийн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар ХААН Банкийг сонгож хамтран ажиллах гэрээ байгуулсан.
2,3-р сарууд	<ul style="list-style-type: none">МИД-ыг орон нутагт борлуулах даатгалын төлөөлөгчдөд эрх олгох сургалтыг зохион байгуулж, анхны болон давтан шалгалтыг авсан.Туршилтын аймгуудын сумдын удирдлагууд, ТХН-ийн ажилтнуудад МИД-ын талаарх сургалтыг зохион байгуулсан.
3-р сарын эцэс	<ul style="list-style-type: none">Даатгалын төлөөлөгчид эрх олгох тусгай комиссыг ТХН, СЯ, СЗХ-ны төлөөлөлтэйгээр байгуулсан.Эрх олгох тусгай комиссын хурлаар нийт 144 даатгалын төлөөлөгчид МИД-ын 2006 оны борлуулалтыг орон нутагт гүйцэтгэх эрх олгосон.Даатгалын компаниудад баталгааны маягт, гэрчилгээ, дардасыг хүлээлгэн өгч борлуулалтын улирал эхлэх бэлтгэл хангасан.Зурагт хуудас, нугалбар, даатгагчдад зориулсан товхимол, сонин зэрэг хэвлэмэл сурталчилгааны материалуудад хэвлэж тараасан.
4-р сар	<ul style="list-style-type: none">МИД-ын борлуулалтын улирал нээгдэж, даатгалын төлөөлөгчид орон нутагт борлуулалтын үйл ажиллагаагаа эхэлсэн.Борлуулалтын улирал эхэлсэнтэй холбогдуулан туршилтын аймгуудын дийлэнх сумдуудад ажиллаж, ТХН-ийн ажилтнууд, даатгалын компани, даатгалын төлөөлөгчдийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө өгсөн.Нүүр тулсан сургалт орон нутагт явагдаж эхэлсэн.



	<ul style="list-style-type: none"> • МИД-ын борлуулалтыг бүртгэх программ хангамжийг туршилтын аймгууд дахь даатгалын компани болон ГХН-д суурилуулсан. • Туршилтын аймгуудын сум тус бүрийн ХААН Банкны салбар нэгжид МИД-ын хураамжийн орлого төвлөрөх данс нээгдсэн.
5-р сар	<ul style="list-style-type: none"> • МИД-ын программ хангамжийн эхний хувилбар боловсруулагдсан. • МИД-д хамрагдсан малчдад хөнгөлөлттэй зээл олгох асуудлаар тохиролцоонд хүрч, ХАС Банк, Монгол Шуудан Банктай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
6-р сар	<ul style="list-style-type: none"> • МИД-ын программ хангамжийг эхний хувилбарыг даатгалын компаниудад суурилуулж холбогдох сургалтыг зохион байгуулсан.
7-р сар	<ul style="list-style-type: none"> • Туршилтын аймгуудад ажиллан МИД-ын борлуулалтын улирлыг хаан, даатгалын компаниудаас хүчинтэй болон хүчингүй баталгааны маягтууд, гэрчилгээ, дардасыг цуглуулан бүртгэсэн. • Орон нутаг дахь даатгалын компаниудын борлуулалтын мэдээллийн санг битүүмжлэн программ хангамжийг хаасан.
8-р сар	<ul style="list-style-type: none"> • Даатгалын компаниудтай МИД-ын борлуулалтын хэмжээг тулган, давхар даатгалын зардал, баталгаат нөхөн төлбөрийн бодит хэмжээ, ҮДБ-ний нөөцийн данс, ГХБ-ний нөөцийн данс, МИДНТ-ийн дансанд цуглах хөрөнгийн хэмжээг тодорхойлсон. • ХААН банкинд МИД-ын ҮДБ-ний нөөцийн данс, ГХБ-ний нөөцийн дансыг тус тус нээсэн.

МИД-ын 2006 оны борлуулалт

МИД-ын анхны борлуулалтын улирал 2006 оны 4-р сарын 1-нд туршилтын Увс, Хэнтий, Баянхонгор аймгийн нийт 56 сумдад эхэлснээс хойш 2006 оны 7-р сарын 10 хүртэлх хугацаанд төсөлд орлцогч даатгалын компаниуд нийт 2410 малчинтай МИД-ын ҮДБ болон ГХБ-ний гэрээг байгуулж, 86,0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.





Баянхонгор аймаг

Баянхонгор аймгийн хувьд нийт 947 малчин даатгалд хамрагдсан нь тус аймгийн малчдын 8.3 хувь, МИД-д хамрагдсан малчдын 39,2 хувь болж байна. Тус аймагт Монгол Даатгал, Түшиг Даатгал компаниуд борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж нийт 43.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь МИД-ын 2006 оны борлуулалтын орлогын 51 хувийг эзэлж байна.

Хүснэгт №1

Баянхонгор аймаг	Монгол Даатгал		Түшиг Даатгал		Аймгийн дүн		
	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	
1	Баянхонгор	227,749	10	492,194	17	719,943	27
2	Баацагаан	484,247	13	46,575	1	530,822	14
3	Баянбулаг	2,546,490	48	747,707	14	3,294,197	62
4	Баянговь	187,250	5	206,625	5	393,875	10
5	Баянлиг	439,521	9	3,252,068	69	3,691,589	78
6	Баян-Овоо	3,717,041	77	0		3,717,041	77
7	Баян-Өндөр	206,250	2	3,033,422	36	3,239,672	38
8	Баянцагаан	2,794,292	43	0		2,794,292	43
9	Богд	0		2,051,372	50	2,051,372	50
10	Бөмбөгөр	950,831	35	498,953	30	1,449,784	65
11	Бууцагаан	236,404	2	258,504	2	494,908	4
12	Галуут	3,883,223	100	3,936,160	92	7,819,383	192
13	Гурванбулаг	598,428	15	0		598,428	15
14	Жаргалант	2,578,313	29	736,119	11	3,314,432	40
15	Жинст	513,097	11	24,380	2	537,477	13
16	Заг	0		254,063	3	254,063	3
17	Өлзийт	466,651	22	675,256	13	1,141,907	35
18	Хүрээмарал	1,304,068	43	3,065,157	85	4,369,225	128
19	Шинэжинст	0		849,900	18	849,900	18
20	Эрдэнэцогт	305,751	10	2,066,964	25	2,372,715	35
Бүгд		21,439,606	474	22,195,419	473	43,739,296	947

Монгол Даатгал компани Баянхонгор аймгийн бүх сумдад борлуулалт хийх эрх бүхий 22 төлөөлөгч, Түшиг Даатгал компани 17 суманд борлуулах хийх эрх бүхий 18 төлөөлөгчтэйгөөр ажилласан.

Увс аймаг

Увс аймгийн хувьд нийт 1185 малчин МИД-д хамрагдсан нь туршилтын аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь аймгийн нийт малчдын 12 хувь, МИД-д хамрагдсан малчдын 49,1 хувийг эзэлж байна. Борлуулалтын орлого 29,4 сая төгрөг болсон нь МИД-ын 2006 оны борлуулалтын 34,3 хувийг эзэлж байна.

Хүснэгт №2

Увс аймаг	Монгол Даатгал		Түшиг Даатгал		Прайм Даатгал		Аймгийн дүн		
	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	
1	Улаангом	924,358	20	142,706	5	120,169	27	1,187,233	52
2	Баруунтуруун	106,684	9	0		223,647	12	330,331	21
3	Бөхмөрөн	32,000	1	0	0	139,446	9	171,446	10
4	Давст			140,240	9	434,817	30	575,057	39
5	Завхан	1,245,024	44	0		701,956	20	1,946,980	64
6	Зүүнговь	2,499,137	71	239,891	5	1,031,370	23	3,770,398	99
7	Зүүнхангай	478,656	13	0		1,650,930	35	2,129,586	48
8	Малчин	805,050	47	570,965	36	223,200	7	1,599,215	90
9	Наранбулаг	876,647	26	256,089	24	1,782,870	53	2,915,606	103
10	Өлгий			2,394,615	80	300,715	17	2,695,330	97



Малын индексжүүлсэн даатгал төсөл

11	Өмнөговь	854,828	39	0		1,498,383	50	2,353,211	89
12	Өндөрхангай	414,540	14	947,694	50	1,417,730	50	2,732,864	113
13	Сагиль	301,734	6	382,391	7	0		684,125	13
14	Тариалан	664,100	34	454,534	30	361,691	24	1,480,325	88
15	Түргэн			7,326	1	1,285,448	35	1,292,774	36
16	Тэс			58,720	45	198,670	50	257,390	95
17	Ховд	874,330	29	55,803	5	909,293	30	1,839,426	64
18	Хяргас	572,750	22	160,723	17	0		733,473	39
19	Цагаанхайрхан	104,599	6	618,587	18	0		723,186	24
Бүгд		10,754,437	381	6,430,284	332	12,280,335	472	29,417,956	1,184

Монгол Даатгал компани Увс аймгийн 19 сумдад борлуулалт хийх эрх бүхий 25 төлөөлөгч, Түшиг Даатгал компани 18 суманд борлуулалт хийх эрх бүхий 16 төлөөлөгч, Прайм Даатгал компани 18 суманд борлуулалт хийх эрх бүхий 15 төлөөлөгчтэйгээр ажилласан.

Хэнтий аймаг

Хэнтий аймгийн хувьд нийт 279 малчин МИД-д хамрагдсан бөгөөд аймгийн нийт малчдын 4,2 хувь, МИД-д хамрагдсан малчдын 11,5 хувийг эзэлж байна. Борлуулалтын орлого 12,5 сая төгрөг болсон нь МИД-ын 2006 оны борлуулалтын 14,6 хувийг эзэлж байна.


Монгол Даатгал компани Хэнтий аймгийн 17 сумдад борлуулалт хийх эрх бүхий 15 төлөөлөгч, Түшиг Даатгал компани 17 суманд борлуулалт хийх эрх бүхий 12 төлөөлөгч, Прайм Даатгал компани 14 суманд борлуулалт хийх эрх бүхий 19 төлөөлөгчтэйгээр ажилласан.

Хүснэгт №3

Хэнтий аймаг	Монгол Даатгал		Түшиг Даатгал		Прайм Даатгал		Аймгийн дүн		
	Борлуулалтын орлого	Даатгуулагч дын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагч дын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагч дын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагч дын тоо	
1	Батноров	321,396	9	625,869	8	407,218	10	1,354,483	27
2	Батширээт	231,480	5	0		0		231,480	5
3	Баян-Адрага	515,752	8	0		218,900	3	734,652	11
4	Баян-Овоо	1,975,453	35	120,317	2	0		2,095,770	37
5	Баянмөнх	68,324	2	0		0		68,324	2
6	Баянхутаг	130,894	3	0		131,423	1	262,317	4
7	Биндэр	460,706	8	0		91,464	4	552,170	12
8	Галшар	747,381	12	20,528	1	26,560	2	794,469	15
9	Дадал	380,742	8	56,259	4	325,536	11	762,537	23
10	Дархан	1,456,915	36	173,770	5	124,000	1	1,754,685	42
11	Дэлгэрхаан			0		337,238	10	337,238	10
12	Жаргалтхаан	178,345	9	110,034	5	95,000	2	383,379	16
13	Мөрөн	13,329	2	0		253,850	6	267,179	8
14	Норовлин	1,248,060	12	0		0		1,248,060	12
15	Хэрлэн	46,170	1	83,064	4	185,855	7	315,089	12
16	Өмнөдэлгэр	15,000	1	121,028	8	440,716	4	576,744	13
17	Цэнхэрмандал	679,675	21	440,178	8	0		1,119,853	29
Бүгд		8,469,621	172	1,751,047	45	2,637,760	61	12,858,429	278



Даатгалд хамрагдсан малын 37 хувийг ямаа, 30 хувийг үхэр, 23 хувийг хонь, 10 хувийг адуу, 0,1 хувийг тэмээн сүрэг эзэлж байна. Даатгалд хамрагдсан малын бүтцийг дараах графикт үзүүлэв.



Даатгалын компани

Монгол Даатгал компани 62, Түшиг Даатгал компани 46, Прайм Даатгал компани 34 эрх бүхий даатгалын төлөөлөгчидтэйгээр туршилтын аймгуудад МИД-ын борлуулалтыг гүйцэтгэсэн.


МИД-ын борлуулалтын орлогын хэмжээг оролцогч даатгалын компани тус бүрээр харуулбал:

Даатгалын компаниуд	ҮДБ-ний борлуулалтын орлого		ГХБ-ний борлуулалтын орлого		Борлуулалтын нийт хэмжээ	
	/төгрөгөөр/	/хувиар/	/төгрөгөөр/	/хувиар/	/төгрөгөөр/	/хувиар/
Монгол Даатгал	39627943	47.4%	1035720	43.2%	40663663	47.3%
Түшиг Даатгал	29409747	35.2%	967000	40.4%	30376747	35.3%
Прайм Даатгал	14525776	17.4%	392320	16.4%	14918096	17.4%
Дүн	83563467	100%	2395040	100%	85958507	100%

МИД-ын борлуулалт хийгдсэн малчдын тоо даатгалын компани тус бүрээр харуулбал:

Оролцогч даатгалын компаниуд	Баянхонгор аймаг		Увс аймаг		Хэнтий аймаг		Нийт	
	/тоо/	/хувиар/	/тоо/	/хувиар/	/тоо/	/хувиар/	/тоо/	/хувиар/
Монгол Даатгал	474	50.1%	381	32.1%	172	62.3%	1027	42.6%
Түшиг Даатгал	473	49.8%	332	28.0%	45	16.1%	850	35.3%
Прайм Даатгал			472	39.7%	60	21.5%	533	22.1%
Дүн	947	100%	1185	100%	279	100%	2410	100%

Хугацааны хувьд оролцогч даатгалын компаниудын борлуулалт 6-р сарын сүүлч 7-р сарын эхээр эрчимжиж, даатгалын төлөөлөгчид урьд өмнө тохиролцсон малчдаас хураамжаа хураан авч, даатгалын гэрээг олноор байгуулах хандлагатай байсан.



МИД-ын нөөцийн дансууд

МИД-ын 2006 оны борлуулалтын улиралд оролцсон даатгалын компаниудын давхар даатгалын хураамж, Баталгаат нөхөн төлбөрийн хандивийн хэмжээг урьдчилсан байдлаар тооцоолж доорх хүснэгтэд үзүүлэв.

Оролцогч даатгалын компаниуд	Давхар даатгалын хураамж /төг/	Давхар даатгалын хураамжийн хувь	Баталгаат нөхөн төлбөрийн хандив бодитоор /төг/	Урьдчилан төлсөн Баталгаат нөхөн төлбөрийн хандив /төг/	Баталгаат нөхөн төлбөрийн хандивийн зөрүү /төг/
Монгол Даатгал	13,332,759.00₮	33.6%	15,314,157.00₮	20,000,000	4,685,843.00₮
Түшиг Даатгал	11,419,222.00₮	38.8%	12,889,709.00₮	20,000,000	7,110,291.00₮
Прайм Даатгал	5,460,419.00₮	38.6%	6,187,108.00₮	20,000,000	13,812,892.00₮
Дүн	30,212,400.00₮	100%	34,390,974.00₮	60,000,000	25,609,026.00₮

Оролцогч даатгалын компаниудад олгох зөвхөн ГХБ-ний гэрээнд олгох урамшууллын тооцоо, ГХБ-ний нөөцийн дансны урьдчилсан хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Оролцогч даатгалын компаниуд	Зөвхөн ГХБ-ний борлуулалт	Зөвхөн ГХБ-ний гэрээнд олгох урамшуулал	ГХБ-ний нөөцийн данс
Монгол Даатгал	400,760.00₮	97,360.00₮	938,360.00₮
Түшиг Даатгал	480,960.00₮	135,520.00₮	831,480.00₮
Прайм Даатгал	260,640.00₮	102,680.00₮	289,640.00₮
Дүн	1,142,360.00₮	335,560.00₮	2059480.00

МИД-ын 2006 оны борлуулалтын үр дүнд урьдчилсан байдлаар ҮДБ-ний нөөцийн дансанд 30,212,400.00 төгрөг, ГХБ-ний нөөцийн дансанд 2059480.00 төгрөг, МИДНТ-ийн дансанд 87738634.00 төгрөг төвлөрөх тооцоолол гарсан.